

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 173

Улаанбаатар хот

Зарим тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.13, 20.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Хорооны 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын 4.2.4 дэх заалтын даатгалын нэмэлт хураамж гэсэн хэсгийн дараах “+ даатгалын шимтгэл + татвар” гэснийг хассугай.

2.Хорооны 2007 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын 2.2.3-т заасан “... хойш 2 жил болсон байх” гэснийг “Шунахай сэдэлттэй болон банк санхүүгийн хууль тогтоомж зөрчсөнтэй холбоотой гэмт хэрэг үйлдээгүй, хэрэв үйлдсэн бол Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд заасан ялгүйд тооцох хугацаа нь өнгөрсөн байх” гэж өөрчилсүгэй.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН